

К-51



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Нийслэлийн тээврийн талаар баримтлах бодлогын
баримт бичиг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2, 25 дугаар зүйлийн 25.1, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг 1 дүгээр хавсралтаар, Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийслэлийн тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТТУЛГА

Э.Б.Т

16.07.2014

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2014 оны 17 сарын 26 өдрийн
118 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ /2020 он/

Нэг. Нийтлэг үндэслэл

Авто тээврийн салбарын ажил үйлчилгээ нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил болон иргэд, зорчигчдын аж амьдралд ихээхэн нөлөө үзүүлж байдаг учраас энэ салбарын хөгжилд тулгамдаж буй асуудлуудыг оновчтой зөв тодорхойлж, шуурхай шийдвэрлэж байх шаардлагатай байна.

Хотын ерөнхий төлөвлөлт, авто замын нэгдсэн сүлжээ, эдийн засгийн чадавхтай уялдуулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн зөв харьцааг хангах замаар Нийслэл хотын тээврийн үйлчилгээний одоогийн байгаа тогтолцооны зарчмыг өөрчлөн шинэ шатанд гаргаж, үр дүнтэй ажиллахыг хотын өнөөгийн амьдрал зайлшгүй шаардаж байгаа тул "Нийслэлийн тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг"-ийг боловсруулсан болно.

Нийслэлийн тээврийн салбарыг хөгжүүлэх тэргүүлэх зорилтууд болон шийдвэрлэх асуудлуудыг тусгасан, ойрын болон дунд хугацааны үйл ажиллагааны Энэхүү хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар нийслэл хотын иргэд, оршин суугчдын тээврийн үйлчилгээний эрэлт, хэрэгцээг хангасан, зорчигчдын эрх ашгийг дээдэлсэн аюулгүй, соёлч шуурхай тээврийн үйлчилгээг бий болгоход оршино.

"Нийслэлийн тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг" нь нийслэлийн тээврийн салбарт дэвшилтэт техник технологи, автопаркын шинэчлэлийг үе шаттайгаар хийх, хүн ам, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй нийтийн тээврийн хэрэгслээр хангаж үйлчлэх, жолооч, тээвэрчдийг мэргэшүүлэн сургах, цалин урамшуулалыг нэмэгдүүлэх, нийгмийн хангамжийн асуудлыг шийдвэрлэх, нийтийн тээврийн замнал төлөвлөлтийг оновчтой төлөвлөх, зохион байгуулах, тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтыг сайжруулах, нийтийн тээврийн үйлчилгээний хөлс төлөлтөд цахим систем нэвтрүүлэх, ачаа, зорчигч тээврийн терминаль, логистик төвүүдийг байгуулах, Улаанбаатар хотод шинээр тавигдах Метро, хөнгөн галт тэрэг болон тусгай замын автобусны үйлчилгээг бусад төрлийн нийтийн тээврийн үйлчилгээтэй хэрхэн уялдуулан зохицуулах зэрэг асуудлыг шийдвэрлүүлэн үе шаттай хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Бодлогын баримт бичгийн зорилго

Нийслэлийн тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн зорилго нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртлэх хөгжлийн чиг хандлагад хотын тээврийн салбарыг хөгжүүлэхээр тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх, салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, байгаль орчинд хор нөлөө багатай стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэл ашиглах, тээврийн логистик тогтолцоог бүрдүүлэх замаар иргэд зорчигчдын тээврийн үйлчилгээний эрэлт, хэрэгцээг найдвартай хангасан аюулгүй, соёлч шуурхай, тээврийн үйлчилгээний тогтвортой системийг бий болгоход оршино.

Гурав. Бодлогын баримт бичгийн тэргүүлэх чиглэлүүд

- 3.1. Хурдан шуурхай, тохилог найдвартай их багтаамжийн нийтийн тээврийн үйлчилгээ бий болгох замаар хувийн автомашины хэрэглээг бууруулах;
- 3.2. Нийтийн тээврийн үйлчилгээнд тээврийн шинэ төрөл болон дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх;
- 3.3. Нийтийн тээврийн үйлчилгээний хөлс төлөлтийн системийг боловсронгуй болгох;
- 3.4. Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх төр хувийн хэвшлийн оролцооны зохистой харьцааг хадгалах;
- 3.5. Тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх;
- 3.6. Ачаа тээврийн логистик тогтолцоог хөгжүүлэх замаар тээвэрлэлтийн эдийн засгийн үр ашгийг тооцож, тооцоо судалгаанд үндэслэн нэмэгдүүлэх;

Дөрөв. Бодлогын баримт бичгийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 4.1. Нийтийн зорчигч тээвэр:
 - 4.1.1. Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний их, дунд багтаамжийн автобусны паркыг үе шаттайгаар шинэчлэх, стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр бүрдүүлэх;
 - 4.1.2. Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд бүртгэл хяналтын /GPS/ систем, тээвэрлэлтийн цахим төлбөрийн систем зэрэг дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх замаар тээврийн үйлчилгээг зохицуулах "Цахим" тогтолцоог бий болгох;
 - 4.1.3. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, үйлчилгээний чанар соёл, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх;
 - 4.1.4. Нийтийн тээвэрт суурилсан хот байх үндсэн зарчмыг баримтлан дэвшилтэт техник технологи, программ хангамжийг ашиглан нийтийн тээврийн сүлжээг оновчтой төлөвлөж, өндөр үр ашигтай тээврийн төрлийг түлхүү хөгжүүлэх;
 - 4.1.5. Нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч бүр төлбөрөө төлж зорчдог болох, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутаны нийтийн тээврээр зорчих нөхөн олговрыг тэдэнд олгодог тэтгэвэр, халамж, тэтгэлэг дээр нэмж олгодог болох асуудлыг судлаж, Засгийн газрын түвшинд шийдвэрлүүлэх;
 - 4.1.6. Улаанбаатар хотод Метро, тусгай замын автобус /BRT/ зэрэг багтаамж ихтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх нарийвчилсан судалгааг хийх, ажлын зураг төсвийг боловсруулах, бэлтгэл ажлыг хангаж, хэрэгжүүлэх;
 - 4.1.7. Алсагдсан гэр хороолол, суурьшлын цэгүүдийн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж, төрлийг нэмэгдүүлэх;
 - 4.1.8. Автотээврийн байгууллагуудын удирдлага, инженер техникийн ажилтнуудын мэргэжлийн үр чадварыг байнга дээшлүүлэх, үйл ажиллагааны өртөг зардлыг бууруулах;
 - 4.1.9. Салбарын хөгжлийн шаардлагыг хангахуйц мэдлэг, чадвар, туршлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэх, автотээврийн аюулгүй байдлыг хангахуйц жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх;
 - 4.1.10. Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд олон улсын стандартыг нэвтрүүлж, нутагшуулах;
 - 4.1.11. Шинээр байгуулагдах дагуул хотуудтай холбогдох тээврийн төлөвлөлтийг боловсруулж, үйлчилгээг зохион байгуулах;
 - 4.1.12. Дотооддоо автобус, троллейбус угсрах үндэсний үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах;

4.1.13. Тээврийн үнэ тарифийг шатахууны үнэ, валютийн ханшны хэлбэлзэл болон бодит зардал дээр үндэслэн тогтоож байх, хөлс төлөлтийн системийг боловсронгуй болгон тээврийн үнэ тарифийг индексжүүлэн тогтоох;

4.1.14. Төлбөрийн цахим систем нэвтрүүлснээр нийтийн тээврээр үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр зорчдог эрх бүхий иргэдийн унааны зардлыг цахим картаар дамжуулан тооцож олгодог системд шилжүүлэх;

4.1.15. Хувийн хэвшлийн хөрөнгө орлуулалтаар таксины тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх;

4.2. Ачаа тээвэр:

4.2.1. Улаанбаатар хотын доторх болон хот орчим, дагуул хотуудын ачаа тээврийн салбарыг цахим тогтолцоонд оруулан, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;

4.2.2. Хот доторх болон хот орчмын аюултай ачааны тээвэрлэлт, хүнсний технологийн болон ахуйн тээвэр эрхлэгчдийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг бий болгох, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;

4.2.3. Улаанбаатар хот орчимд ачаа тээврийн төрөлжсөн терминал, логистик төв байгуулах;

4.3. Авто үйлчилгээ:

4.3.1. Автотээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний мэдээллийн санг бий болгох талаар эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

4.3.2. Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд нэгдсэн шалгалт хийх, зэрэглэл тогтоох, үйлчилгээний жишиг үнэ тарифыг боловсруулах, чанарын баталгаа өгдөг тогтолцоог бий болгох;

Тав. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

Нийслэлийн тээврийн салбарыг 2020 он хүртэл хөгжүүлэх бодлогын баримт бичгийн ерөнхий нөхцлийг дараах байдлаар тодорхойлов:

5.1. Санхүүжилтийн эх үүсвэр: Нийслэлийн тээврийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- Улс, нийслэлийн төсөв, төсөл;
- Орон нутгийн төсвөөс санг үүсгэн байгуулахад зориулан олгосон санхүүгийн дэмжлэг;
- Гадаад улс орон, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, дэмжлэг хандив, хөнгөлөлттэй зээл;
- Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлт хийсэн аж ахуйн нэгж байгууллагуудаас эргэн төлөгдөх төлбөр;
- Хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

5.2. Хэрэгжүүлэх механизм: Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, шинэ техник технологи нэвтрүүлэх, стандартын шаардлага хангасан автобусаар паркын шинэчлэлт хийх, метро, тусгай замын автобус зэрэг багтаамж ихтэй тээврийн төрлийг үе шаттай нэвтрүүлнэ.

5.3. Хэрэгжүүлэх хугацаа: 2020 он хүртэл,

5.3.1. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөө 2 үе шаттай байна.

- I шат /2014-2016 он/ - Нийслэлийн тээврийн салбарыг 2016 он хүртэл хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;
- II шат /2017-2020 он/ - Нийслэлийн тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлж дуусгах;

5.4. **Эцсийн үр дүн:** Нийслэл хотын иргэдийн эрэлт хэрэгцээг хангасан аюулгүй, соёлч, шуурхай найдвартай тээврийн үйлчилгээний тогтолцоог бий болгоно.

Зургаа. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллагууд

Энэхүү бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд Зам, тээврийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Тээврийн газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, ачаа, зорчигч тээврийн үйлчилгээ болон авто үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд оролцоно.

Долоо. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэлбэр

7.1. Нийслэл хотын тээврийн салбарыг хөгжүүлэх талаар төр, засгаас баримтлах бодлогын баримт бичгүүдэд заасан чиглэл, зорилт, арга хэмжээний хүрээнд:

7.1.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дараах чиг үүрэгтэй оролцоно:

- Өөрчлөх хууль, тогтоол, дүрэм, журмын төслийг холбогдох журмын дагуу өргөн барьж шийдвэрлүүлэх;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс нийслэлийн төсөвт тусгах арга хэмжээ авч ажиллах;
- Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх талаар гадаад улс орон болон олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага харилцах, хамтран ажиллах;

7.1.2. Нийслэлийн Тээврийн газар дараах чиг үүрэгтэй оролцоно:

- Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний их, дунд багтаамжийн автобус, троллейбусны паркыг шинэчлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх шаардлага, тооцоо судалгааг гарган хэрэгжүүлэх;
- Тээврийн эрэлт хэрэгцээг тодорхойлох нарийвчилсан тооцоо, судалгааг холбогдох газруудтай хамтарч хийх;
- Хөтөлбөрийн хүрээнд гарсан тогтоол шийдвэрийг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

7.1.3. Нийслэл хотод ачаа, зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага дараах чиг үүрэгтэй оролцоно:

- Хөтөлбөрийн хүрээнд эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах;

7.2. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга зам, хууль эрх зүйг боловсронгуй болгох

7.2.1. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газар, Зам тээврийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үүрэг, хариуцах ажлаар нь нарийвчлан боловсруулж батлуулах;

7.2.2. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгө оруулалт, эдийн засгийн тооцооллыг нарийвчлан төлөвлөж улс, нийслэлийн жил бүрийн төсвийн орлого, санхүүгийн эх үүсвэртэй уялдуулах;

7.2.3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн акт, тушаал, шийдвэрүүдийг цаг тухайд нь боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах.

7.3. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд анхаарах гол асуудлууд

7.3.1. Тохиолдож болох эрсдэл, саад бэрхшээлийг урьдчилан судалж нарийвчлан тооцоолох, түүнээс сэргийлэх, арилгах, даван туулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

7.3.2. Мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, тулгарч буй асуудлуудыг хамтарч шийдвэрлэх;

7.3.3. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхдээ Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлого, Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, бүсчилсэн хөгжлийн цогц бодлого болон бусад бодлогын баримт бичгүүдийн үйл ажиллагааг нягт уялдуулан хэрэгжүүлэх;

7.3.4. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх явц болон эцсийн үр дүнг шалгах, хянах, үнэлэх үнэлгээний системийг шинээр боловсруулж мөрдөх;

Найм. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

8.1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёл болон аюулгүй, найдвартай байдал дээшилж, иргэд нийтийн тээврээр зорчих сонирхол нэмэгдэж, улмаар замын хөдөлгөөний түгжрэл саатал багасна;

8.2. Нийслэл хотын нийтийн тээврийн үйлчилгээний цагийн хуваарь, чиглэл маршрутын талаарх бодит мэдээллийг иргэд цаг алдалгүй авах боломж бүрдэнэ;

8.3. Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр бүрдэнэ;

8.4. Автотээврийн хэрэгслээс ялгарах агаарын бохирдлын хэмжээ буурна;

8.5. Тээвэрлэлтийн хөлс төлөлтийн уян хатан системийг бий болгосноор гол гудамж, замаар дайран өнгөрөх нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн давхцал буурах нөхцөл бүрдэнэ;

8.6. Ачаа тээврийн логистик тогтолцоо хөгжүүлснээр тээвэрлэлтийн зардал буурч бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжих, хүнсний аюулгүй байдалд хяналт тавих боломж бүрдэхээс гадна нийслэл хотын замын хөдөлгөөний эрчим сайжирч, агаарын бохирдол буурах нөхцөл бүрдэнэ.

Ес. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд тохиолдож болох эрсдлийн төсөөлөл

9.1. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр дутагдах, улс, нийслэлийн төсөвт тусгагдахгүй байх магадлал өндөр байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтэнд нөлөөлөх гол эрсдэл байх болно.

**НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2014 оны 27 сарын 27-ний өдрийн
18 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.



Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллагууд	Хэрэгжүүлэх хугацаа
1	2	3	4	5	6
Нэг. Хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар					
1.	1.1. Тээврийн салбарын бодлогын болон хууль, эрх зүйн актуудыг боловсруулах, шинэчлэх	1.1.1. Төрөөс автотээврийн талаар баримтлах бодлого болон Автотээврийн тухай хуулийг шинэчлэх талаар Зам, тээврийн яамнаас боловсруулж байгаа баримт бичгийн төсөлд нийслэл хотын тээврийн үйл ажиллагааны чиглэлээр санал боловсруулж тусгуулах; 1.1.2. Нийслэл хотын нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдөх "Улаанбаатар хотын дүрэм"-ийн төсөлд тээврийн үйлчилгээний талаарх санал боловсруулж, тусгах.	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ НЗДТГ	2014-2015 он
2.	1.1.3. Нийтийн тээвэрт тулгуурласан тээврийн тогтолцоог бий болгон хүртээмжийг нэмэгдүүлэх замаар суудлын авто машины хэрэглээг бууруулах талаар зохих судалгаа хийж, санал боловсруулж, хэрэгжүүлэх.		Нийслэлийн Тээврийн газар	НЗДТГ ЗТЯ	2014-2015 он
3.					

4.		<p>1.1.4. Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолоор батлагдсан "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги"-ийн хүрээнд нийслэл хотын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дунд болон богино хугацааны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах.</p>	<p>Нийслэлийн Тээврийн газар</p>	<p>НЗДТГ ХЗЯ ЗТЯ ЗЦГ ЗХУТ</p>	<p>2014-2015 он</p>
5.	<p>1.2. Нийтийн тээврээр үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр зорчих тухай холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж, үйлчилгээний хөлс төлөлтийг боловсронгуй болгох</p>	<p>1.2.1. Боловсролын тухай, Цагдаагийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай зэрэг хуулиудад заасан нийтийн тээврээр үнэгүй болон хөнгөлөлттэй үнээр зорчих эрх бүхий иргэдийн унааны зардлын хуваарилалт болон нийтийн тээврээр зорчих хөлс төлөлтийг боловсронгуй болгох талаар санал боловсруулан УИХ, Засгийн газарт оруулах.</p>	<p>Нийслэлийн Тээврийн газар</p>	<p>НЗДТГ ХЗЯ ЗТЯ БШУЯ НХХЯ СЯ</p>	<p>2014-2015 оны 06 сар</p>
6.	<p>Боловсронгуй болгох</p>	<p>1.2.2. Нийтийн тээврийн үйлчилгээнд цахим төлбөрийн систем нэвтрүүлэх болон ашиглахтай холбогдсон дүрэм, журам боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах.</p>	<p>Нийслэлийн Тээврийн газар</p>	<p>ЗТЯ НЗДТГ ХЗЯ Монгол банк</p>	<p>2014-2016 он</p>
7.	<p>1.3. Тээврийн салбарт мөрдөгдөх дүрэм журам, стандарт, норм</p>	<p>1.3.1. Нийтийн тээврийн хэрэгслийн жолоочийн ажил, амралтын дэглэмийг зохицуулах, нийтийн тээврийн үйлчилгээний жолооч нарын үндсэн цагингийн нэгдсэн жишиг тогтоох, цагингийн тодорхой хувийг төрөөс санхүүжүүлэх зэрэг цогц асуудлаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх.</p>	<p>Нийслэлийн Тээврийн газар</p>	<p>ЗТЯ НХХЯ НЗДТГ АТУТ</p>	<p>2014-2015 оны 06 сар</p>
8.	<p>нормативыг боловсронгуй болгох</p>	<p>1.3.2. Ачаа, зорчигч тээврийн автовокал болон автотерминал, ложистик тэвүүдийг шинээр байгуулах төсөл, хөтөлбөр боловсруулахад хамтарч ажиллах, хотын доторх болон хот орчмын тээврийн үйлчилгээний төрийн зохицуулалтыг сайжруулах.</p>	<p>Нийслэлийн Тээврийн газар</p>	<p>ЗТЯ ХЗЯ НЗДТГ НЕТГ АТУТ</p>	<p>2015 оны III улирал</p>

9.		1.3.3. Шатдаг хийн түлшээр ажилладаг автомашины аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээнд мөрдөж ажиллах шаардлагатай стандарт, дүрэм журмыг боловсруулахад хамтарч ажиллах.	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ МХЕГ НМХГ НОВГ	2014-2015 он
10.		1.3.4. Нийслэл хотын авто үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийн санг үүсгэж, ангилал, зэрэглэл тогтоох, үйлчилгээнд чанарын баталгаа олгодог тогтолцоог бий болгох талаар холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах.	Нийслэлийн Тээврийн газар	НМХГ ЗТЯ НЗАА	2014-2015 он
11.		1.3.5. Автотээврийн салбарын үйлчилгээний талаарх олон улсын /ISO/ стандартыг жилд 5-аас доошгүй өөрийн орны ашиглалтын онцлог нөхцөл байдалд тохируулан нугалшуулах.	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ СХЭГ	2014-2020 он
12.		1.3.6. Авто тээврийн хэрэгсэл, түүний эд анги, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх, засварлахтай холбоотой шаардагдах норм норматив, стандартыг боловсруулахад оролцож ажиллах.	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ НМХГ НЗАА	2014-2016 он
Хоёр. Хүний нөөцийн бодлого, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах талаар					
13.	2.1.Нийслэл хотын ажлын тээврийн үйлчилгээний удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулах	2.1.1. Хотын тээврийг хөгжүүлэх төслүүдтэй уялдуулан хотын доторх болон хот орчимын ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагааны бүртгэл хяналт, нэгдсэн зохицуулалт хийх, холбогдох байгууллага, иргэдийг мэдээллээр шуурхай хангах зэрэг эрх, үүрэг бүхий мэргэжлийн байгууллага /мэдээллийн нэгдсэн төв/ байгуулах талаар санал боловсруулж Нийслэлийн удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх.	Нийслэлийн Тээврийн газар	НЗДТГ НӨХГ НМТГ	2014-2016 он
14.		2.1.2. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Нийтийн тээврийн үйлчилгээний зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллага болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах.	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ НЗДТГ	2014-2016 он

15.		2.1.3 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч зарим жижиг аж ахуйн нэгж, байгууллагуудыг нэгтгэн үйл ажиллагааны чадамжийг сайжруулах, авто аж ахуйн мэргэжлийн байгууллагын хэлбэрт бүрэн шилжүүлэх;	Нийслэлийн Тээврийн газар	НЗДТГ ЗТЯ	2014-2017 он
16.		2.1.4. Нийслэлийн хотын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн харьцааг зохистой хэмжээнд хүргэх;	Нийслэлийн Тээврийн газар	НЗДТГ ЗТЯ	2014-2018
17.	2.2. Автогээврийн хэрэгслийг мэргэшсэн жолоочоор хангах	2.2.1. Эхний ээлжинд нийслэлийн нийтийн зорчигч тээврийн хэрэгслийг мэргэшсэн ээлжийн жолоочоор хангах талаар холбогдох байгууллагуудтай хамтран тогтмол сургалт зохион байгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ НХХЯ НЗДТГ	2014-2015 он
18.		2.2.2. Нийтийн тээврийн хэрэгслийн болон хүнд даацын автомашины жолооч сургаж дадлагажуулах сургалтын танхим, жолоодогчын талбай бүхий нэгдсэн сургалтын төв байгуулах төсөл боловсруулж, шийдвэрлүүлэх;	Нийслэлийн Тээврийн газар	НЕТГ ЗТЯ НЗДТГ	2014-2015 он
19.	2.3. Салбарын боловсон мэргэжлийн хүчнийг бэлтгэх	2.3.1. Автогээврийн салбарын инженер, техникийн ажилтнуудыг өндөр хөгжилтэй орнуудад сургаж, дадлагажуулах, метро, тусгай замын автобус болон шинээр нэвтрэх бусад тээврийн хэрэгслүүдийн техникийн ашиглалт, үйлчилгээний мэргэжилтэн, ажилтнуудыг бэлтгэх, мэргэшүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ НЗДТГ	2014-2016 он
20.		2.3.2. Авто үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжилтэй ажилтны судалгааг гаргаж, мэргэжил олгох, мэргэшүүлэх сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллах;	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ МИС АУЭХ МСҮТ-УУД	2014-2016 он
21.	2.4. Тээвэрчдийн нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх	2.4.1. Тээвэрчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх төсөл боловсруулж, "Тээвэрчин хотхон" байгуулах ажлыг эхлүүлэх;	Нийслэлийн Тээврийн газар	НЗДТГ ЗТЯ НЕТГ	2014-2016 он
22.	3.1. Тээврийн хэрэгслийн	Гурав. Салбарын техник, технологийн бодлого зохицуулалтын талаар			
	3.1.1. Нийтийн тээврийн хэрэгслийн техникийн	Нийслэлийн	ЗТЯ	2014-2015	

	<p>Техникийн хяналтын ажиглалгааг сайжруулах</p>	<p>Узлаг үйл ажиллагааг хяналтын төвийн үйл ажиллагааг сайжруулж, техникийн үзлэг хяналтын төвийг шинээр барьж байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх.</p>	<p>Тээврийн газар</p>	<p>НХОГ НЕТГ</p>	<p>оны 10 сар</p>
23.		<p>3.2.1. Нийтийн тээврийн үйлчилгээнд шатдаг хий болон цахилгаан эх үүсвэрээр ажилладаг тээврийн хэрэгслийг өргөнөөр ашиглах замаар автотээврийн хэрэгслээр ялгарах агаарын бохирдлын хэмжээг бууруулах.</p>	<p>Нийслэлийн Тээврийн газар</p>	<p>НЭДТГ ЗТЯ БОНХЯ НМХГ НОВГ</p>	<p>2014-2015 он</p>
24.	<p>3.2. Автотээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах</p>	<p>3.2.2. Хөдөлгөөний ачаалал ихтэй төвийн гудамж заммуудын нийтийн тээврийн үйлчилгээнд багтаамж ихтэй тээврийн хэрэгсэл /залгаа автобус, троллейбус, резинэн дугуйт трамвай/ авч ашиглах асуудлыг судалж шийдвэрлэх.</p>	<p>Нийслэлийн Тээврийн газар</p>	<p>НЭДТГ ЗТЯ</p>	<p>2014-2016 он</p>
25.		<p>3.2.3. Дотооддоо угсарч үйлдвэрлэсэн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний стандартын шаардлага хангасан их багтаамжийн автобусаар паркын шинэчлэлт хийх.</p>	<p>Нийслэлийн Тээврийн газар</p>	<p>НЭДТГ Автобус угсарч, үйлдвэрлэгчид</p>	<p>2014-2015 он</p>
26.		<p>3.2.4. Дизель хөдөлгүүртэй автобус болон хүнд даацын машин механизм, ачааны автомашинд угааны шүүлтүүр суурилуулж, хотын доторх ачаа, зорчигч тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх талгаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.</p>	<p>Нийслэлийн Тээврийн газар</p>	<p>НЭДТГ ЗТЯ БОНХЯ НМХГ НАЧА</p>	<p>2015-2016 он</p>
27.	<p>3.3. Нийтийн тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдалыг сайжруулах</p>	<p>3.3.1. Томоохон авто аж ахуйн нэгж, байгууллагуудыг техникийн үзлэг хяналт явуулах өөрийн тоног төхөөрөмж бүхий үйлчилгээний нэгжтэй болгох ажлыг хэрэгжүүлж эхлэх.</p>	<p>Нийслэлийн Тээврийн газар</p>	<p>ЗТЯ АТУГ НЭДТГ СХЗГ</p>	<p>2015-2016 он</p>

28.	3.4. Бэрхшээлтэй нийтийн зорчих бүрдүүлэх Хөгжлийн иргэдийн тээврээр боломжийг	3.4.1. Автотээврийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хөгжлийн бэрхшээлтэй /тэргэнцэртэй/ иргэд зорчих боломжтой тусгай зориулалтын тоноглол бүхий нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүд	3ТЯ НХХЯ НЗДТГ	2014-2016 ОН
29.	3.5. Таксийн тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх	3.5.1. Улаанбаатар хотын таксийн тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллахын зэрэгцээ хууль бус такси үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх.	Нийслэлийн Тээврийн газар	3ТЯ ЗЦГ ЗХУТ НМХГ	2014-2016 ОН
Дөрөв. Тээврийн ажил үйлчилгээний төлөвлөлт, хяналт зохицуулалтын талаар					
30.	4.1.1. Улаанбаатар хотын доторх болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээний зорчигч урсгал, зорчигч эргэлтийн нарийвчилсан судалгаа хийх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.	4.1.2. Хөдөлгөөний ачаалал ихтэй төв замуудаар дайран өнгөрдөг нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн давхцлыг үе шаттайгаар бууруулах төлөвлөлт хийж, хэрэгжүүлэх.	Нийслэлийн Тээврийн газар	3ТЯ НЗДТГ	2014-2015 ОН
31.	4.1. Хотын хүн амын зорчигч урсгал, зорчигч эргэлтийн судалгаа хийж нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлтийг боловсронгуй болгох	4.1.3. Хотын төв замуудын ачааллыг бууруулах үүднээс хотын захын чиглэлүүдийн автобусыг богино эргэлтээр явуулахын тулд нийтийн тээврийн хэрэгслийн эргэж тойрох зам, талбай болон зорчигчдын сэлгэн суух буудал, зогсоол байгуулах /5 шар, Саппоро, Ботаник, Офицеруудын ордон, 7 буудал орчимд/ зураг төсөв боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.	Нийслэлийн Тээврийн газар	ЗЦГ НАЗГ НЗДТГ	2014-2015 ОН
32.			Нийслэлийн Тээврийн газар	НАЗГ НЗЦГ ЗХУТ НЕТГ НӨХГ	2014-2015 ОН

33.		4.1.4. Улаанбаатар хотын хүн амын суурьшил, авто замын сүлжээний өөрчлөлттэй уялдуулан нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн төрөл болон чиглэлийг оновчтой төлөвлөж, үйлчилгээг ойртуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах.	Нийслэлийн Тээврийн газар	ЗЦГ НАЗГ ЗХУТ	2014-2015 он
34.		4.1.5. Нийтийн тээврийн үйлчилгээнд тусгай замын автобус /BRT/, Метро зэрэг тээврийн шинэ төрөлтэй уялдуулан нийтийн тээврийн чиглэлийн сүлжээг оновчтой төлөвлөн зохион байгуулах.	Нийслэлийн Тээврийн газар	ЗЦГ НЕТГ НАЗГ ЗХУТ	2014-2020 он
35.		4.2.1. Нийслэл хотын нийтийн тээврийн үйлчилгээнд зориулалтын, экологийн хувьд стандартын шаардлагад нийцсэн зорчигч тээврийн хэрэгсэл ашиглах, угсарч үйлдвэрлэх талаар хөрөнгө оруулалтын төсөл боловсруулж, үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээ авах.	Нийслэлийн Тээврийн газар	НЭДТГ ЗТЯ УХААДЯ	2014-2016 он
36.	4.2. Нийтийн зорчигч тээвэрт шинэ техник технологийг нэвтрүүлэх замаар зориулалтын хөдлөх бүрэлдэхүүнээр хангаж, үйлчилгээний чанар соёлыг дээшлүүлэх	4.2.2. Улаанбаатар хотод "BRT" буюу тусгай замын автобусны үйлчилгээ нэвтрүүлэх ажлын зураг, төсөв боловсруулах, дэд бүтцийг барьж байгуулахад хамтран ажиллах. 4.2.3. Улаанбаатар хотод "Метро"-ны үйлчилгээ нэвтрүүлэх нарийвчилсан судалгаа хийх, ажлын зураг, төсөв боловсруулах болон холбогдох байгууллагуудаас санал авах, бэлтгэл ажлыг хангахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ НЭДТГ НЕТГ НАЗГ	2014-2016 он
37.	4.2. Нийтийн зорчигч тээвэрт шинэ техник технологийг нэвтрүүлэх замаар зориулалтын хөдлөх бүрэлдэхүүнээр хангаж, үйлчилгээний чанар соёлыг дээшлүүлэх	4.2.4. Нийслэл хотын хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан цахилгаан тээврийн үйлчлэх хүрээ, чиглэлийн зохион байгуулалт болон троллейбусны депо, дэд бүтцийн байгууламж, шугам сүлжээг төслийн хүчин чадалд нь хүргэж шинэчлэн ашиглах талаар төсөл боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.	Нийслэлийн Тээврийн газар	НЭДТГ ЗТЯ "ЦТ" ОНӨАДАТГ	2014-2017 он
38.					2015 оны 06 сар

39.		4.2.5. Нийтийн тээврийн үйлчилгээний цагийн хуваарь, автобусны чиглэл, зогсоол болон үйлчилгээтэй холбоотой мэдээллийг хурдан шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлэх, автобусны буудал зогсоол дээр мэдээллийн цахим дэлгэц байрлуулах, эцсийн зогсоолуудыг камержуулах, нийтийн тээврийн үйлчилгээнд тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналт, удирдлагын цахим систем нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх.	Нийслэлийн Тээврийн газар	НЭДТГ НМТ ЗТЯ АТҮТ	2014-2016 он
40.	4.3. Хүнсний технологийн болон тээвэрлэлтийн ажиглагаанд хяналт тавих	4.3.1. Улаанбаатар хотын доторх болон хот орчмын хүнсний болон технологийн тээвэр эрхлэгчдийн үйл ажиллагааны дүрэм журам, стандартыг мөрдүүлэх, хяналт тавих ажил үүргийг сайжруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ АТҮТ НМХГ ЗЦГ	2014-2016 он
41.	4.4. Авто худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн ажил үйлчилгээний чанар дээшлүүлэх	4.4.1. Нийслэл хотод авто сэлбэг хэрэгслийн худалдаа эрхлэгчдийн судалгааг гаргаж, мэдээллийн санг бүрдүүлэх, чанарын баталгаатуй хуурамч сэлбэг хэрэгсэл, эд ангийг худалдаж буй эсэхэд эрх бүхий байгууллагатай хамтран хяналт шалгалт хийж ажиллах. 4.4.2. Ашиглалтаас хөсөгдсөн тээврийн хэрэгсэл, эд ангийг задалж устгах, дахин боловсруулах, түүхий эд болгон ашиглах талаар холбогдох байгууллагатай хамтран төсөл боловсруулж хэрэгжүүлэх.	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ НМХГ НЗАА	2014-2015 он
42.		Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ НЗАА	2015-2016 он	
Тав. Тээвэрлэлтийн үнэ тарифийн тогтолцоог боловсронгуй болгох талаар					
43.	5.1. Тээврийн хөлс төлөлтийн системийг боловсронгуй болгох	5.1.1. Тээврийн үйлчилгээний үнэ тарифийг эдийн засгийн үр ашгийн зарчим, дотоодын нөхцөл байдалтай уялдуулан бодит зардал дээр үндэслэн шинэчлэн тогтоож байх.	Нийслэлийн Тээврийн газар	ЗТЯ НЭДТГ	2014-2020 он

44.		5.1.2. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд хөлс төлөлтийн цахим төлбөрийн системийг нэвтрүүлэх, тээвэрлэлтийн зайнаас хамгааруулж зорчигчийн үнэ тарифийг ялгавартай тогтоох суурь судалгааны ажлуудыг хийж, техник эдийн засгийн тооцооны аргачлал боловсруулах;	Нийслэлийн Тээврийн газар	ЭТЯ НЭДТГ	2014-2016 он
Зургаа. Иргэд, зорчигчдын санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, олон нийттэй харилцах талаар					
45.	6.1.Иргэд, зорчигчдын санал, хүсэлтийг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх механизмыг боловсронгуй болгох	6.1.1. Иргэдээс санал гомдол хүлээн авах "Call center" байгуулах, санал гомдлын барагдуулалтыг чанаржуулах, мэдээллийг ил тод болгох;	Нийслэлийн Тээврийн газар	НЭДТГ	2014-2015 он
46.	6.2.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах стратегийг шинэ түвшинд түвшинд нийслэлчүүдийн нийтийн үйлчлүүлэх дээшлүүлэх	6.2.1. Гадаад орнуудын нийтлэг туршлагын дагуу нийтийн тээврийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг албан ёсны нэг эх сурвалжаас олон нийтэд үнэн зөв, шуурхай хүргэх зорилгоор "Мэдээллийн студий"-тай болох; 6.2.2. Иргэд, олон нийтэд нийтийн тээврийн үйлчилгээ, холбогдох хууль дүрэм, журам стандартын талаар видео танилцуулга, нийтийн тээврийн салбарын түүхэн замналаар аялгуулах гэрэл зургийн үзэсгэлэнгийн танхимыг байгуулах; 6.2.3. Нийслэлийн иргэд, зорчигчдын нийтийн тээвэрээр үйлчлүүлэх хотын соёлыг дээшлүүлэх зорилгоор тус мэдээллийн студий, танилцах танхимд тогтмол арга хэмжээ зохион байгуулж хэвшүүлэх;	Нийслэлийн Тээврийн газар	НЭДТГ НӨХГ	2014-2015 он
48.			Нийслэлийн Тээврийн газар	НЭДТГ	2014-2016 он

